

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ШУУРХАЙ АЖЛЫН ХЭСГИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022.01.14  
11.00

Улаанбаатар хот  
Төрийн ордон  
ЦАХИМ

Улсын онцгой комиссын Шуурхай ажлын хэсэг 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 11.00 цагт Шадар сайдын өрөөнд цахимаар хуралдав. Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, УОК-ын Нарийн бичгийн дарга Т.Баярхүү, Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Ц.Уртнасан, Шадар сайдын зөвлөх П.Оюунчимэг, МХЕГ-ын Тэргүүн дэд дарга Л.Төгсбаяр, ЦЕГ-ын нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдал хангах албаны дарга, цагдаагийн хурандаа Н.Лхагвасайхан, Нийслэлийн Засаг даргын орлогч, Нийслэлийн шуурхай штабын дарга Р.Дагва, ХӨСҮТ-ийн захирал Ц.Билэгтсайхан, ХӨСҮТ-ийн дэд захирал Ж.Байгальмаа, Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дэд дарга Д.Уранзаяа, Эрдэмтдийн багийн гишүүд оролцов. Хурлаар Коронавируст халдварт /Ковид-19/-ын нөхцөл байдал, хариу арга хэмжээний талаар Эрүүл мэндийн яам, Нийслэлийн онцгой комисс, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Эрдэмтдийн зөвлөлийн мэдээллийг сонсож, Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан хугацаатай үүрэг даалгавар өгөв.

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Коронавируст халдварт /Ковид-19/-ын эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар, хүртээмж, зохион байгуулалтыг сайжруулж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангарт, нийлүүлтэд онцгой анхаарч ажиллах, тасалдал, хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах,

Эрүүл мэндийн сайд С.Энхболд,

Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга Б.Бямбадорж нарт

2. Нийслэлийн хэмжээнд амбулаториор Коронавируст халдварт /Ковид-19/-ын эмнэлгийн тусlamж үйлчилгээ үзүүлэх ажлыг тогтмолжуулж, тухайн үйлчилгээний талаарх /байршил, цагийн хуваарь, зохион байгуулалт/ мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээх,

Эрүүл мэндийн сайд С.Энхболд,

Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга Б.Бямбадорж

ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга Т.Ганзуул нарт

3. Гэрээр тусгаарлагдан эмчлэгдэж байгаа иргэдэд цахимаар болон хэвлэлийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан зөвөлгөө мэдээлэл өгөх ажлыг өдөр тутам, тогтмол зохион байгуулах,

Эрүүл мэндийн яам,  
Нийслэлийн эрүүл мэндийн газар,  
Нийслэлийн шуурхай штабт

4. Дүүргүүдийн тандалтын багийн үйл ажиллагааг 24 цагаар тогтмол ажиллуулах, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавих,

Нийслэлийн шуурхай штабын дарга Р.Дагва,  
Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга Б.Бямбадорж нарт

5. Коронавируст халдварт /Ковид-19/-ын эсрэг хариу арга хэмжээг өдөр тутмын удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах Улсын онцгой комиссын Шуурхай ажлын хэсгийг Улсын онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуянаар ахлуулан байгуулж ажиллах,

Улсын онцгой комиссын орлогч дарга,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян  
Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга,  
дэд хурандаа Т.Баярхүү нарт

6. Коронавируст халдварт /Ковид-19/-ын эмчилгээ, үйлчилгээнд ашиглах эм, эмнэлгийн хэрэгслийг татан авах ажлыг 2022 оны 01 дугээр сарын 20-ны өдрийн дотор зохион байгуулж, тасалдал, хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн даруй авч ажиллах, эрүүл мэндийн байгууллага, эм ханган нийлүүлэх байгууллагуудын санхүүжилт, өр төлбөрийн асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд яаралтай шийдвэрлэх,

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг,  
Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга Б.Цэцэгсайхан

7. Улсын онцгой комиссын Шуурхай ажлын хэсэг Коронавируст халдварт /Ковид-19/-ын эсрэг хариу арга хэмжээний гүйцэтгэл, эмнэлгүүдийн эмийн нөөц, эмнэлгийн тусlamж үйлчилгээний нөхцөл байдлыг тогтмол хянаж, биечилсэн хяналт шалгалтыг хуваарийн дагуу зохион байгуулах,

Улсын онцгой комиссын Шуурхай ажлын хэсэг

8. Эрдэмтдийн багийн тооцоолол, зөвлөмжид үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасалдуулахгүйгээр хөдөлгөөний эрчим, халдвартарын тархалтын эрсдэлийг бууруулах, халдвартарын тархалтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй олон нийтийг хамарсан зарим арга хэмжээг богино хугацаанд хязгаарлах зэрэг саналаа Улсын онцгой комисст танилцуулах

Эрүүл мэндийн сайд С.Энхболд

9. Халдвартарын нөхцөл байдлыг үнэлж их дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг 2022 оны 02 дугаар сард эхлүүлэх эсэх асуудлаар нэгдсэн шийдэл гаргаж, олон нийтэд урьдчилж мэдээ, мэдээлэл өгөх,

Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан,  
Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт

10. Улсын онцгой комиссын 2022 оны 01 дугээр сарын 10-ны өдрийн 01 дугээр хуралдааны тэмдэглэлийн 1.3-т заасныг үндэслэн байгууллага, аж ахуйн нэгжүүд өмчийн хэлбэр үл харгалзан өөрийн байгууллагад ажиллаж байгаа бага насны хүүхэдтэй /0-5

насны/ эцэг, эх, өрх толгойлсон эцэг, эхийг нэг сарын хугацаанд цахимаар ажиллуулж, халдвартын эрсдэлээс хамгаалах зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмж гаргаж, олон нийтэд хүргэх, хэрэгжилт, гүйцэтгэлийн талаар мэдээ, мэдээллийг нэгтэж танилцуулах,

Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын дарга,  
бригадын генерал Б.Ууганбаяр,  
аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт

11. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд хязгаарлалтад ороогүй байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн ажилтан, албан хаагчдын тээврийн хэрэгслийг цахим зөвшөөрөлд /QR код/ үндэслэн хөдөлгөөнд оролцуулахад шаардлагатай программыг хэрэглээнд бэлэн болгож, 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Улсын онцгой комисст танилцуулах,

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны

Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Б.Болор-Эрдэнэ,  
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумьяабазар,  
Тагнуулын ерөнхий газрын дарга, хошууч генерал П.Одонбаатар,


Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Т.Гантулга


Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд,  
Автомээврийн үндэсний төвийн захирал Б.Гурсоронзон нарт

12. Коронавируст халдвар /Ковид-19/-ын “Омикрон” хувилбарын тархалттай холбоотой Улсын онцгой комиссын дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлийн хийсэн тооцоолол, зөвлөмжийг хэсэгчилсэн байдлаар иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар түгзэх,

ЗГХЭГ-ЫН Хэвлэл мэдээлэл,  
олон нийттэй харилцах газрын дарга Т.Ганзууд

## УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС

Хянасан:  
УОК-ын Нарийн бичгийн дарга,  
дэд хурандаа  Т.Баярхүү

Тэмдэглэл хөтөлсөн:  
УОК-ын Ажлын албаны мэргэжилтэн,  
ахлах дэслэгч  Х.Бундхорол